

Мандах Их Сургууль

Б И Д М Э Д Л Э Г Э Э Р Б А Я Л Г И Й Г Б Ү Т Э Э Н Э

Мандах их сургуулийн 2018 оны онцлох амжилт, үйл явдал



⇒ БСШУС-ын сайдын 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/078 тоот тушаалаар “Мандах бүртгэл” их сургууль гэсэн нэрээ “Мандах” их сургууль болгон өөрчлөв.

⇒ Мандах их сургууль үндэсний хэмжээнд 3 дахь удаагаа магадлан итгэмжлэгдэв.

⇒ Мэдээлэл технологийн тэнхимийг Мандах их сургуулийн бүрэлдэхүүний “Мэдээлэл технологийн” сургууль болгон өргөтгөв.



⇒ Хотын төвд орчин үеийн стандарт, шаардлага хангасан хичээлийн анги танхим, оффис, спорт заал, номын сан, зоогийн газар бүхий хичээлийн шинэ цогцолбор хичээлийн байртай болов.

⇒ Дэлхийн бизнесийн нэгдсэн холбооноос “2018 оны шилдэг байгууллага”-аар өргөмжлөгдөв.



⇒ АНУ-ын Виржиниагийн их сургуультай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.

⇒ Хөгжлийн шийдэл ТВБ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан Студент ентэрпренёр төвийн үйл ажиллагааг нээв.

⇒ Нийгмийн хариуцлагын хүрээнд сургуулийн зэргэлдээх нийтийн эзэмшлийн зам талбайг 15 сая төгрөгөөр шинэчлэн засварлав.



⇒ Бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрийг МИУЗ-өөс магадлан итгэмжлэв.

⇒ Докторын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж эхлэв.

⇒ “Инженер эдийн засаг”-ийн өдрийн хөтөлбөр шинээр нээв.

Мандах Их сургууль хичээлийн шинэ байртай боллоо

Мандах их сургуулийн хичээлийн шинэ байрны нээлтийн ажиллагаа 2018 оны 09 сарын 06-ны өдөр ёслол төгөлдөр боллоо.

1992 онд анх 10 хүрэхгүй багш 60 гаруй оюутантай түрээсийн байранд сургалтын ажиллагаагаа эхлүүлж байсан сургууль маань өнөөдөр хотын А зэрэглэлийн бүсэд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн орчин үеийн техник, технологийн өндөр түвшний тоног төхөөрөмжөөр тоноглогдсон анги танхим бүхий хичээлийн шинэ жилийн байртай боллоо. Нээлтийн үйл ажиллагааг тус сургуулийн захирал, профессор Г.Нанжид нээж, үе үеийн багш, ажиллагсад, төгсөгчид болон хамтран ажилладаг байгууллага хувь хүмүүст талархлаа илэрхийлэв.

Ёслолын үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн зочид Мандахчуудад баяр хүргэж үг хэллээ. Хувийн их, дээд сургуулиудын холбооны УЗ-ийн гишүүн С.Нямзагд хэлсэн үгэндээ: “Мандах их сургуулийн сургалтын хөтөлбөр Монгол Улсад нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэхэд онол, арга зүйн хувьд жинтэй хувь нэмэр оруулсан ба үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэх байгууллагаар хамгийн анх магадлан итгэмжлүүлсэн, төгсөгчид нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, Монголын хувийн их, дээд сургуулиудыг түүчээлж яваа сургууль юм” хэмээн хэлсэн юм.



Мандах их сургуулийн 27 дахь хичээлийн шинэ жил эхэллээ

Мандах их сургуулийн 2018-2019 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн ажиллагаа 2019 оны 8-р сарын 27 –нд боллоо.

Энэ удаагийн хичээлийн шинэ жилийн нээлтийн нэг онцлог нь хотын А зэрэглэлийн бүсэд буюу БГД-ийн 16-р хорооны нутаг дэвсгэрт баригдсан хичээлийн шинэ байрандаа оюутнуудаа хүлээн авч байгаа бөгөөд орчин үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон анги танхим, номын сан, спортын заал, зоогийн газартай шинэ хичээлийн цогцолбортой болсонд оюутан багш, ажиллагсад сэтгэл өндөр байна. Хичээлийн шинэ жилийг нээж, Мандах их сургуулийн захирал, профессор Г.Нанжид үг хэлж, хамт олныхоо ажлын амжилт, сургуулийн үйл ажиллагаанд гарсан ахиц дэвшлийг алдаршууллаа. Манай хамт олны хувьд:

- Сургууль маань их сургуулийн статустай болсон,

- Байгууллагын III шатны

Магадлан итгэмжлэлийн шалгуурыг үндэсний хэмжээнд хамгийн түрүүнд хангаж батламжлагдсан,

- Чанарын удирдлагын ISO-9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлсэн анхны сургууль болсон,

- Европын ассамблейн “Бүс нутгийн шилдэг байгууллага”-ын шагналыг Монгол улсаас анх удаа хүртсэн,

- Магистрын хөтөлбөрөө магадлуулсан,

- Докторын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх авсан,

- Шинээр Инженер эдийн засгийн хөтөлбөр нээх болсон зэрэг олон сайхан амжилтуудыг өнгөрсөн хичээлийн жилд гаргасан байна.

Нээлтийн үеэр уламжлал ёсоор 2017-2018 оны хичээлийн жилд амжилттай суралцсан болон ЭЕШ-ийн өндөр оноотой оюутнуудад 20-50%-ийн **Хөнгөлөлттэй суралцах эрхийн бичгийг гардууллаа.** Үүнд:

Сурлагын амжилтаар олгох тэтгэлгийг:

- 4 улирал дараалан А үнэлгээтэй суралцсан

О.Сарангуа / НБББанк 3/,

Г.Мөнхтүвшин /НББ-аудит 3/ нарт сургалтын төлбөрийн 30% -ийн хөнгөлөлттэй суралцах эрх

- 2 улирал дараалан А үнэлгээтэй суралцсан С.Цэвээнжаргал /НББ-аудит 3/, С.Дуламсүрэн /Эчнээ-2/ нарт

20%-ийн хөнгөлөлттэй суралцах эрхийн бичгийг гардууллаа.

Өндөр оноотой шинэ элсэгчид олгох тэтгэлгийг:

Б.Номиндарь /НББ-англи хэл/,

Н.Номин /НББ-аудит/,

Г.Урансанаа / НББ-Аудит/,

Г.Лхамсүрэн / НББ-Аудит/,

А.Мишээл /Санхүү менежмент/,

М.Мөнгөнцоож /НББ-Англи хэл/,

О.Бөхбилэг /Санхүү менежмент/,

Б.Аминаа /НББ-татвар/,

П.БилгүүнОчир / НББ-банк/,

Б.Доржсүрэн / НББ-Аудит/,

Д.Оюунбилэг /Санхүү менежмент/,

З.Насуун-Эрдэнэ / НББ-Аудит/,

М.Баянжаргал/ НББ-англи хэл/,

Д.Билэгсайхан /Банкны менежмент/,

Д.Төгсболд /НББ-статистик/,

Э.Зандан-Очир /НББ-татвар/,

Б.Бат-Эрдэнэ /Санхүүгийн менежмент/,

Б.Дэлгэрмагнай /НББ-Аудит/ нар тус тус гардан авлаа.



Г а д а а д х а м т ы н а ж и л л а г а а

Хамтын ажиллагааны хүрээнд Мандах их сургуулийн төлөөлөл Швейцарийн Эдийн засаг, технологийн их сургуульд зочиллоо

Мандах их сургууль нь Швейцарийн Эдийн засаг, технологийн их сургуультай хос диплом олгох хөтөлбөрийг 2018 оноос эхлэн хамтран хэрэгжүүлж байна.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Мандах их сургуулийн Санхүү, хөгжлийн бодлого эрхэлсэн дэд захирал С.Энхтүвшин, Сургалт эрхэлсэн дэд захирал, доктор, дэд профессор Ч.Төрбадрах 2018 оны 11-р сарын 23-24-ны өдрүүдэд ажлын айлчлал хийж, тус их сургуульд зочиллоо. Зочлох үеэр Швейцарийн Эдийн засаг, технологийн сургуулийн гүйцэтгэх захирал, доктор, профессор Ibrahim Al Souleiman, Маркетинг хариуцсан захирал Chadi Al Souleiman, УЗ-ийн гишүүн, Хүний нөөц хариуцсан ажилтан Murna Al Kayed нартай уулзаж, цаашид хамтран ажиллах чиглэлийн талаар санал солилцов.

Хоёр тал хамтарсан хөтөлбөрийг цаашид амжилттай үргэлжлүүлэх, хөтөлбөр болон оюутны тоог нэмэгдүүлэх талаар ярилцаж, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар харилцан тохиролцлоо.

Уулзалтын үеэр яригдсан нэг гол асуудал нь хоёр сургууль хамтарсан докторын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар урьдчилсан байдлаар тохиролцлоо.



ACBSP-ын 8 –р бүсийн хуралд Мандах их сургуулийн төлөөлөл оролцлоо

Бизнесийн сургууль болон хөтөлбөрийг магадлан итгэмжилдэг олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллага /ACBSP/-ын 8-р бүсийн хуралд Мандах их сургуулийн төлөөлөл оролцлоо.

ACBSP-ын 8-р бүсийн хурал Франц улсын Парис хотноо 2018 оны 11 сарын 16-17 өдрүүдэд болсон ба энэ удаагийн хурлыг Франц улсын International School Management /ISM/ сургууль зохион байгууллаа.

Хуралд ACBSP-ийн ерөнхийлөгч Jeffrey Alderman, Peregrine academy-ийн ерөнхийлөгч Olin Oedekoven, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдах зөвлөлийн дэд дарга бөгөөд ажлын албаны захирал Ж.Ариунболд, ACBSP-ийн гишүүн монголын зарим их дээд сургуулиудын төлөөлөл оролцсон ба Мандах их сургуулийг төлөөлж Санхүү, хөгжлийн бодлого эрхэлсэн дэд захирал С.Энхтүвшин, Сургалт эрхэлсэн дэд захирал, доктор, дэд профессор Ч.Төрбадрах нар оролцлоо.

Хурлын үеэр Мандах их сургуулийн төлөөлөгчид Францын Олон улсын менежментийн сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал, доктор Matthew Andrews-тай уулзаж, тус сургуультай хамтран ажиллах чиглэлийн талаар харилцан санал бодлоо солилцлоо.

Түүнчлэн дээрх 8-р бүсийн хурлыг угтаж, 2018 оны 11 сарын 1-15-ны хооронд зохион байгуулагдсан бизнес симуляцийн онлайн тэмцээнд Мандах их сургуулийн оюутны баг идэвхитэй, амжилттай оролцсон талаар доктор Matthew Andrews уулзалтын үеэр танилцуулсан байна.

Д о т о о д х а м т ы н а ж и л л а г а а

Мандах их сургууль, Хөгжлийн Шийдэл ТББ-ын хооронд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа

Мандах Их Сургууль Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран ажиллахаар санал нэгдэж, санамж бичигт Мандах Их Сургуулийн Захирал Г.Нанжид, Хөгжлийн Шийдэл ТББ-ын Төслийн Менежер Б.Хишигсүрэн нар гарын үсэг зурлаа.

Мандах Их сургууль Хөгжлийн Шийдэл ТББ-ын хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд тус сургуулийн оюутнуудад Бизнес санааг гаргах, Бизнес загвар болон төсөл хэрхэн боловсруулах, нийгмийн Энтрепренёршипыг хөгжүүлэх зэрэг сургалтуудыг зохион байгуулахаас гадна гарааны бизнесийг эхлүүлэх, бизнесийн шинэ санаа дэмжих, тэднийг ирээдүйн Нийгмийн Энтрепренёрууд болгон хөгжүүлэхэд туслах юм.

Хөгжлийн шийдэл ТББ нь 2013 онд Лондон хотод төвтэй Youth Business International олон улсын байгууллагын гишүүнээр элсэн “Залуусын бизнесийг дэмжих санаачлага” хөтөлбөрийг Монгол улсад хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь 18-35 насны залуусыг нийгмийн энтрепренёр болгон хөгжүүлж, бизнес эрхлэх, түүнийг дэмжин ажлах зорилготой юм. Дэлхийн энтрепренёруудын өдрийг жил бүрийн 11-р сарын 3 дахь долоо хоногийн Мягмар гаригт тэмдэглэдэг. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Хөгжлийн Шийдэл ТББ нь салбар оффисын нээлтээ 2018 оны 11-р сарын 23-ны өдөр Мандах их сургуулийн Б блокийн 3-р давхарт зохион байгуулахаар боллоо.

Уралдаан тэмцээн

Мандах их сургуулийн доктор багш Н. Сэлэнгэ тэргүүн байр эзэллээ

Монгол Улсад орчин үеийн хүн амын тооллого явуулсны 100 жилийн ойн хүрээнд Үндэсний Статистикийн Хорооноос судлаачид, их, дээд сургуулиудын оюутнуудын дунд зохион байгуулагдсан “XX зууны Монгол Улсын хүн амын дүр төрх болон нийгэм эдийн засгийн түүхэн онцлог үйл явдал ба хүн амын асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд, Удирдлагын академийн багш доктор Г.Жаргал, Мандах Их Сургуулийн багш, Доктор (Ph.D) Н.Сэлэнгэ нарын бэлтгэсэн **"Монгол Улсын 100 жилийн хүн амын төлөв байдал, хандлага"** сэдэвт хамтын судалгааны ажил судлаачдын ангилалд тэргүүн байр эзэлсэн байна.

Энэхүү судалгааны хүрээнд Монгол Улсын хүн амын 1918-2015 оны (100 жил) хоорондох 10 удаагийн тооллогын (улс, нийслэл, 21 аймаг, 331 сум) дүн мэдээнд Холт-Винтерийн аргаар шинжилгээ хийж, 2020-2045 оны хэтийн хандлагыг улс, нийслэл, аймгаар тодорхойлсон юм.

Монгол Улсын хүн амын өсөлтийн хувь 1990 оноос буурч, хүн амын шилжилтийн III үе шатанд орсон, нэг төвтэй хотжилт эрчимтэй явагдсаны үр дагавараар 2020-2045 онд Улаанбаатар хотын хүн ам 3.3-4.6 саяд хүрч, харин хөдөөгийн сумын хүн ам 0.7-0.9 хувиар буурах хандлагатай байгаа зэргийг судалгаандаа дурдсан байна.



Мандах их сургуулийн оюутнууд Олон улсын оюутны эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцлоо

2018 оны 12 сарын 17-нд Г.В. Плехановын нэрэмжит Эдийн засгийн их сургуулиас зохион байгуулсан “**Economy and innovative development**” сэдэвт Олон улсын оюутны эрдэм шинжилгээний хуралд Мандах их сургуулийн оюутнууд амжилттай оролцлоо. Хурлын хэлэлцүүлэг англи, орос хэл дээр явагдсан бөгөөд 2-р шатанд 14 илтгэл шалгарч хэлэлцүүлэгдсэн бөгөөд Мандах их сургуулиас тавьсан 2 илтгэл II ба Ш-р байрыг эзэллээ.



Монголын их дээд сургуулийн нягтлан бодох бүртгэлийн багш нарын дунд зохион байгуулагдсан 2018 оны “Татварын бүртгэл”-ийн улсын V олимпиадад Мандах их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш **Б.Ганбагана** тэргүүн байр эзэллээ.



Эссэ бичлэгийн уралдаан

Дэлхийн философийн өдрийг тохиолдуулан Бизнесийн харилцаа ёс зүй хичээл судалж буй I курсын оюутнуудын дунд зохион байгуулсан “**Ёс зүй бол амьдрах урлаг**”, I, III курсын оюутнуудын дунд “**Нийгмийн тулгамдсан асуудал ба ёс зүй**” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг зохион байгуулж, дүнгээ гаргалаа.

Тус уралдаан нь оюутнуудыг ёс зүйтэй иргэн, мэргэжилтэн болж төлөвших, мэдлэгийн хүрээгээ тэлэх, харилцааны чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготойгоор жил бүр зохион байгуулагддаг. Уралдаанд 261 оюутан бүтээлээ ирүүлснээс дараах оюутнуудын бүтээл эхний гурван байрт шалгарлаа. Үүнд:

I курс

Тэргүүн байр- НББ-Аудит ангийн оюутан Ц.Золзаяа

Дэд байр- НББ-Татвар ангийн оюутан Б.Баярцэцэг

Гутгаар байр- НББ-Англи хэлний ангийн оюутан М.Маргад-Эрдэнэ

III курс

Тэргүүн байр- НББ- Банкны ангийн оюутан О.Сарангуа

Дэд байр- НББ-Татварын ангийн оюутан Б.Тэмүүлэн

Гутгаар байр- НББ-Англи хэлний ангийн оюутан П.Цагаанхүү нарын бүтээлүүд тус тус шалгарлаа.


Гавьяа шагналууд

Дэлхийн бизнесийн нэгдсэн холбооноос Мандах их сургуулийг “Шилдэг байгууллага”- аар тодруулав

Дэлхийн бизнесийн нэгдсэн холбооноос “One world-One award” уриан дор “THE BIZZ AMEA-2019” ёслолын арга хэмжээг БНХАУ-ын Хонг-Конг улсад 2018 оны 11 сарын 14-15 өдрүүдэд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Мандах их сургуулийг төлөөлж, Санхүү, хөгжлийн бодлого эрхэлсэн дэд захирал С.Энхтүвшин, Сургалт эрхэлсэн дэд захирал, доктор, дэд профессор Ч.Төрбадрах нар оролцлоо.

Арга хэмжээний үеэр байгууллагын танилцуулга, сурталчилгааг хэрхэн оновчтой, богино хугацаанд хүртээмжтэй хийх талаар сургалт семинар зохион байгуулсан ба уг семинарын үеэр Мандах их сургуулийн үйл ажиллагааны танилцуулга хийж, хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

Дэлхийн бизнесийн нэгдсэн холбоо нь 120 орны 3000 гаруй аж ахуйн нэгж, байгууллагыг эгнээндээ нэгтгэдэг бөгөөд байгууллагыг чадавхижуулах, бизнесийн зөвөлгөө өгөх, шилдэг байгууллагуудыг шалгаруулж, өргөмжлөх, сайн туршлага дэлгэрүүлэх зэрэг үйл ажиллагааг явуулдаг.



Мандах их сургуулийн Номын сан “Оны онцлох бүтээн байгуулалт”-ын эзнээр тодорлоо

Номын сангийн тухай хууль 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан өдрийг тохиолдуулан Монголын номын сангийн концерциумаас жил бүр оны шилдгүүдээ шалгаруулдаг уламжлалтай. Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй номын сангуудын төлөөлөл 10 номинацид нэр дэвшин оролцсоноос Мандах их сургуулийн номын сан “2018 оны Онцлох бүтээн байгуулалт” шагнал хүртлээ. Уг арга хэмжээнд Мандах их сургуулийг төлөөлж Санхүү, хөгжлийн бодлого эрхэлсэн дэд захирал С. Энхтүвшин, Ахлах номын санч Л. Дэлгэрцэцэг, номын санч Д. Ганцэцэг нар оролцлоо.

2018-2019 оны хичээлийн жилд сургуулийн шинэ цогцолбор барилга ашиглалтанд орсноор багш, ажилтны ажиллах нөхцөл, оюутнуудын суралцах таатай орчин бүрдсэн ба үүний чухал хэсэг нь чөлөөт уншлагын танхим, багаар ажиллах өрөө, Е-судалгааны танхим, ганцаарчилсан уншлагын хэсэг бүхий орчин үеийн шинэ номын сан ашиглалтанд орсон явдал юм.





МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

Баянгол дүүрэг, 16-р хороо,
Амарсанаагийн гудамж 18/1,
Улаанбаатар хот, Монгол,
Шуудангийн хаяг: УБ-16040, Ш/Х:88,
Мандах Их Сургууль

7018-5950, 7018-5949

info@mandakh.edu.mn

АЛСЫН ХАРАА

ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХҮЛЭЭН
ЗӨВШӨӨРӨГДСӨН СУРГАЛТ-СУДАЛГААНЫ ИХ
СУРГУУЛЬ БОЛОХ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ,
ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦСЭН
БОЛОВСРОЛЫН ЧАНАРТАЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ,
ОЮУНЛАГ ЧАДВАРЛАГ СУДЛААЧ МЭРГЭЖИЛТЭН
БЭЛТГЭНЭ.

УРИА

“БИД МЭДЛЭГЭЭР БАЯЛГИЙГ БҮТЭЭНЭ”

ҮНЭТ ЗҮЙЛС

- ЧАНАРТАЙ СУРГАЛТ
- ЧАДВАРЛАГ МЭРГЭЖИЛТЭН
- ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГА
- ОЮУНЛАГ, ХҮНЛЭГ, НЭГДМЭЛ БАЙДАЛ

